

*"Тийнхүү чи Намайг хайж,  
Намайг бүх л зүрхээрээ эрвэл олох болно."*

**Бурханыг  
яаж мэдэх  
вэ?**

## БУРХАНЫГ ЯЖ МЭДЭХ ВЭ?

Абрахам дуулгавартай даруу байдлаараа “Бурханы анд” байсны адил та ч гэсэн Бурханыг таньж, Түүний өршөөл, амар амгалан, ивээлийг авч болно. Итгэлээрээ Бурханыг таньж мэдэх нь хүний амьдралд тохиох хамгийн чухал үйл явдал мөн. Чин сэтгэлээсээ Бурханыг хайсан хүнд Тэрээр Өөрийгөө илчилдэг нь юутай гайхамшигтай.

Хэрэв та өөрийн гэмээс татгалзаад, үнэхээр Бурханд бууж өгөх юм бол Түүний сүнс таны дотор орших болно. Түүний амлалтанд найдаж, дуулгавартай байхад юу ч таныг Бурханаас салгаж чадахгүй. Тэр таны Бурхан байж та Түүнийх байх болно. Тэр таны төлөө их төлөөс төлсөн учир тантай одоо ба мөнхөд харилцаатай байхыг хүсч байгааг та мэдэх болно.

Бурханы үгийг иш татсан эдгээр ишлэлүүдийг уншиж байхад ойлгох чадварыг өгөөч гэж Түүнээс гуй. Бурхан үгээ ариун хүмүүст онгод оруулан бичүүлээд өнөөг хүртэл Сатаны устгах гэсэн бүхий л оролдлогоос хамгаалсан юм.

## ТЭР БОЛ ЦОРЫН ГАНЦ ҮНЭН БУРХАН

“ЭЗЭН бол бидний Бурхан. Эзэн бол ганц. Чи өөрийн Бурхан ЭЗЭНИЙГ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла.“

- *Дэд хууль 6:46, 5*

... Тэнгэрийг бүтээсэн ЭЗЭН ингэж айлдаж байна. (Тэр бол газрыг бий болгосон Бурхан юм. Тэр газрыг хоосноор бүтээгээгүй бөгөөд хүмүүсийг оршин суулгахын тулд бүтээсэн билээ.) “Би бол ЭЗЭН. Өөр байхгүй...“

- *Исаиа 45:18*

“Үүнээс дэлхийн бүх ард түмэн ЭЗЭН бол Бурхан бөгөөд, өөр бурхан байдаггүй юм гэдгийг ойлгох болтугай.“

- *Хаадын дээд 8:60*

“Би бол ЭЗЭН. Энэ бол Миний нэр. Би Өөрийн алдрыг бусдад, Өөрийн магтаалыг сийлмэл хөргүүдэд өгөхгүй.“

- *Исаиа 42:8*

“Та нар бол Миний гэрч нар“ гэж ЭЗЭН айлдаж байна. “Та нар бол Миний зарц нар. Та нар мэдэж, Надад итгэж, Намайг Тэр мөн гэж таниасай гэсэндээ Би та нарыг сонгосон. Надаас өмнө бий болсон Бурхан байгаагүй бөгөөд, Миний дараа ч байхгүй. Би, зөвхөн Би бол ЭЗЭН мөн бөгөөд Надаас өөр аврагч байхгүй.”

- *Исаиа 43:10, 11*

“Над уруу эргэж аврагдагтун. Учир нь Би бол Бурхан, өөр байхгүй!”

- *Исаиа 45:22*

## БУРХАН БОЛ ӨРШӨӨЛ ЭНЭРЛИЙН ЭЗЭН

“ЭЗЭН бол өрөвч, нигүүлсэнгүй. Уурлахдаа удаан болоод хайр энэрлээр элбэг баян. Учир нь тэнгэр газрын дээгүүр өндөрт байдаг шиг Түүнээс эмээгчдэд Түүний хайр энэрэл агуу их юм.”

-Дуулал 103:8, 11

“Харин ЭЗЭНий хайр энэрэл Түүнээс эмээгчдийн дээр мөнхөөс мөнхөд, ... Энэ нь Түүний гэрээг сахигчдад, Түүний заавруудыг биелүүлэхээр санагчдад юм.”

-Дуулал 103:17а, 18б

“Гэнийг уучилдаг Тантай адил Бурхан хэн бэ? Тэр хувиршгүй хайранд баясдаг тул уур хилэнгээ мөнхөд хадгалдаггүй.”

-Мика 7:18

“ЭЗЭНий хайр энэрэл үнэндээ хэзээ ч дуусахгүй. Учир Түүний өршөөл хэзээ ч унахгүй. Тэдгээр нь өглөө бүр шинэ юм.” - Гашуудал 3:22, 23а

“Хэрэв Тэрээр гансралд хүргэдэг бол, Өөрийн арвин их хайр энэрлийн дагуу Тэрээр өршөөх бөлгөө.”

- Гашуудал 3:32

“Энэрэнгүй хүмүүст Та Өөрийн энэрлийг үзүүлдэг.” -Дуулал 18:25а

“ЭЗЭН сайн учир Түүнд талархал өргөгтүн. Учир нь Түүний хайр энэрэл үүрдийнх.” - Шастриын дээд 16:34

“... Та бол нигүүлсэнгүй, өрөвч Бурхан, уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам бөгөөд гай гамшигийг зөвлрүүлэгч гэж би мэдсэн.”

- Иона 4:26

## БУРХАН ЧАМД ХАЙРТАЙ

ЭЗЭН түүнд холоос үзэгдэн “Би чамайг үүрдийн хайраар хайлласан, тийм учраас Би чамайг хайр энэрлээр татсан билээ.“

- *Иер 31:3*

“Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөхийн тулд гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм.“

- *Иер 29:11*

“Би та нарыг хайлласан гэж ЭЗЭН айлдаж байна.“

- *Малахи 1:2a*

“Эцэг хүн үр хүүхдээ өрөвддөгийн адил ЭЗЭН Өөрөөс нь эмээгчдийг өрөвддөг.“

- *Дуулал 103:13*

“Би өөрийн жаргалын төлөө их зовлон амссан. Та миний сүнсийг сүйрлийн нүхнээс хамгаалав. Учир нь миний бүх нуглийг Та нурууныхаа аараар хаясан.“

- *Исаиа 38:17*

“Бурханы биднийг хайлладаг хайрыг нь бид мэдэж итгэдэг. Эхлээд Тэр биднийг хайлласан тул бид хайлладаг юм.“

- *1 Иохан 4:16a, 19*

Чиний бурхан ЭЗЭН, аврагч дайчин, та нарын дунд байна. Тэр та нарын дээр баясал хөөртэйгээр баярлана. Тэр өөрийн хайр дотроо чимээгүй байна. Тэр та нарын дээр баярын уухайгаар баясах болно.

- *Зефания 3:17*

“Бурхан аа! Таны энэрэл хайр хичинээн үнэтэй вэ!“

- *Дуулал 36:7a*

## БУРХАНЫГ МЭДЭХ НЬ ХАМГИЙН ЧУХАЛ

“Харин өөрийн Бурханыг мэдэгч ард түмэн хүчирхэг болж үйлдэл хийнэ.”  
- *Даниел 11:32б*

“... Харин сайрхагч нэгэн нь үүтээр сайрхаг. Намайг мэддэгээр Намайг газар дэлхий дээр хайр, энэрэл, шударга ёс, зөв шударгыг хэрэгжүүлдэг ЭЗЭН гэж ухаардгаараа сайрхаг. Учир нь Би үүнийг таалдаг гэж ЭЗЭН тунхаглаж байна.”

- *Иеремиа 9:24*

“Түүний гэрчлэлүүдийг сахин, Түүнийг бүхий л зүрхээрээ хайгч хүмүүс юутай ерөөлтэй вэ!”

- *Дуулал 119:2*

“Чи болон чиний үр удам амьдрахын тулд амийг сонгож, ЭЗЭН Бурханаа хайллан, Түүний үтийг дуулгавартай дагаж, Түүнээс зуурч бай.”

- *Дэд хууль 30:19б, 20а*

“Учир нь Би тахилаас илүүгээр хайр энэрэлд, шатаалт тахилаас илүүгээр Бурханыг мэдэх мэдлэгт баярладаг.”

- *Хосеа 6:6*

“Буга усны урсгалуудыг хүсэхийн адил Миний сэтгэл, Бурхан Таныг хүсдэг.”

- *Дуулал 42:1*

“Тэр, Миний оршихуй чамтай хамт явж, Би чамд амралтыг өгнө.”

- *Египетээс гарсан нь 33:14*

## БУРХАНААС ТУСГААР АМЬДРАЛ НЬ МӨХӨЛ

“Та нар ЭЗЭНтэй хамт байх үед, Тэрээр та нартай хамт байна. Хэрэв та нар Түүнийг хайвал, Тэрээр та нарт олдоно. Харин та нар Түүнийг умартах аваас Тэр та нарыг умартах болно.” - *Шастырын дэд 15:26*

“Зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй юм. Үүнийг хэн ойлгож чадах билээ.” - *Иер 17:9*

“Хүнд зөв мэт санагдавч, Төгсгөл нь үхэл уруу хөтөлдөг зам байдаг.“

- *Сургаалт үгс 16:25*

“Бурхан нүтэл үйлдсэн тэнгэр элч нарыг хэлтрүүлэлгүй, харин тэднийг тамд хаяад ... Бурханлаг хүмүүсийг сорилтоос ангижруулахыг болон зөвт бус хүмүүсийг шүүлтийн өдрийг

хүргэл шийтгэлийн доор яж барьж байхаа ЭЗЭН мэддэг.“

- *2 Петр 2:4, 9*

“Хэрэв та нар ЭЗЭНИЙ дууг үл сонсож, харин ЭЗЭНИЙ тушаалтыг эсэргүүцэх аваас, ЭЗЭНИЙ мутар та нарын эцэг өвгөдийн эсрэг байсны адил та нарын ч эсрэг байх болно.“

- *1 Самуэл 12:15*

“Хэрэв хэн нэг нь Миний дотор байхгүй бол мөчир мэт хаягдаж, хувхайрна. Хүмүүс тэдгээр мөчрүүдийг түүж, галд хаяхад шатна.“

- *Иохан 15:6*

“...нүгэлтнүүд цөмөөрөө устгагдана, хорон муу хүний хойч үеийнхэн ч таслагдана.“

- *Дуулал 37:38*

## БУРХАНЫГ МЭДЭХИЙН ТУЛД ХАЙ

“Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно.“

- *Иеремия 29:13*

“Хэрэв чи түүнийг цалин цагаан мөнгө мэт эрж, Нууцлагдсан эрдэнэ мэт хайдаг бол, ЭЗЭНээс эмээхүйг чи ухаарна.“ - *Сургаалт үгс 2:4, 5а*

“Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ.“ - *Матай 7:7*

“Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой.“

- *Ефреј 11:6*

“Намайг хайрлагсдыг Би хайрлана. Намайг хичээнгүйлэн хайдаг нь намайг олно.“ - *Сургаалт үгс 8:17*

“Түүнийг хүлээгсдэд, Түүнийг хайсан хүнд ЭЗЭН сайн ажээ.“

- *Гашуудал 3:25*

“Бурхан газрын цээжээр амьдрзуулахаар нэгнээс хүмүүн төрөлхтний үндэстэн бүрийг бүтээж ... хүн Бурханыг эрж хайх ёстойн учир агаад Тэр бид бүхний хэнээс нь ч холгүй хэдий ч хүмүүс Түүнд хүрч, Түүнийг олоосой хэмээсэнд болой.“

- *Үйлс 17:26а, 27*

“Харин миний хувьд, би Бурханыг эрэлхийлж, Бурханы өмнө би өөрийн хэргийг тавихсан.“ - *Иов 5:8*

## БУРХАН ӨӨР РҮҮ НЬ ИРЭХИЙГ ХҮСДЭГ

“Та нарын Бурхан ЭЗЭН нигүүлсэнгүй ... бөгөөд та нар Түүн уруу буцаж ирвэл та нараас нүүрээ буруулахгүй.“ - Шастриын дэд 30:9б

“Учир нь Эзэн Та сайн бөгөөд учлахад бэлэн. Таныг дуудагч бүгдэд хайр энэрлээр элбэг баян.“

- Дуулал 86:5

“Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт хүмүүс та нар гараа цэвэрлэ. Хоёр санаатай хүмүүс та нар зүрхээ ариусга.“

- Иаков 4:8

“ЭЗЭН Өөрийг нь дуудагч бүхэнд, Өөрийг нь үнэнээр дуудагч бүхэнд ойр байдал.“

- Дуулал 145:18

“Нааш ир хамт хэлэлцье“ гэж ЭЗЭН айлдаж байна. Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно.“

- Исаиа 1:18a

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая. Буулгыг минь өөр дээрээ авч Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ делгөөн, даруу билээ. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно.“

- Матай 11:28, 29

“Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй.“

- Иохан 6:376

“Цангасан хүн бүр ус уруу ирэгтүн. Мөнгөгүй хүн бүр ирж, худалдан авч, идэгтүн. Ирж мөнгөгүйгээр, үнэгүйгээр дарс, сүү худалдан авагтун.“

- Исаиа 55:1

## БУРХАН БОЛ АРИУН

“Өө, ЭЗЭН, Бурхдын дунд Тан шиг хэн байна вэ? Ариун байдалдаа сүр жавхлантай ... Тан шиг хэн байна вэ?”

- *Египт 15:11*

“ЭЗЭНтэй адил ариун хэн ч байхгүй ... Бидний Бурхан адил хад гэж байхгүй.”

- *1Салуел 2:2*

“Хорон мууг үйлдэх нь Бурханаас, буруут үйлдэх нь Төгс Хүчтэй Нэгэнээс хол байг.”

- *Иов 34:106*

“Түмэн цэргийн ЭЗЭН Ариун, ариун, ариун. Бүх л газар Түүний алдраар дүүрэн байна.”

- *Исаиа 6:3*

“Мөнх амьдрагч Түүний нэр нь Ариун бөгөөд өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн үүнийг айлдав.”

- *Исаиа 57:15a*

“... Бурханаас өөр хэн ч сайн биш.”

- *Марк 10:18б*

“... Учир нь зөвхөн Та ариун билээ. Бүх үндэстнүүд Таны өмнө ирж, мөргөнө. Учир нь Таны зөвт үйлс илчлэгдсэн.”

- *Иячлэлт 15:4*

“Таны агуу сүрдмээр нэрийг тэд магтан дуулаг! Тэр бол ариун.”

- *Дуулал 99:3*

“Бидний Бурхан ЭЗЭНИЙГ өргөмжилж ... Учир нь бидний Бурхан ЭЗЭН бол ариун!”

- *Дуулал 99:9*

“Байсан, байгаа, мөн хожим ирэх, Төгс хүчтэй ЭЗЭН Бурхан ариун ариун.”

- *Иячлэлт 4:8б*

## БУРХАНЫ ХҮМҮҮС АРИУН АМЬДРАХ ёСТОЙ

“Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг. Чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг бөгөөд чичирдэг юм. Мунхаг хүн ээ, харин чи үйлсгүй итгэл нь ашигтүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байна уу? Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш Үгийг хэрэгжүүлэгчид бологтун.” - *Иаков 2:19, 20, 1:22*

“Хар санаатны зам ЭЗЭНий хувьд жигшүүртэй боловч Шударга зөвийн араас явагчдыг Тэр хайлрладаг.“

- *Сургаалт үгс 15:9*

“Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалтуудыг сахьдагтуй нэгэн бол худалч бөгөөд түүний дотор үнэн байхгүй. Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэггүй аливаа хүн

Бурханых биш. Ах дүүгээ хайлрладагтуй нэгэн нь ч Бурханых биш.“

- *1 Иохан 2:4, 3:10*

“Бүх хүн эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч ЭЗЭНийг үзэхгүй.“

- *Ефрей 12:14*

“Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун.“

- *1 Петр 1:15*

“Та нар амьдрахын тулд мууг биш, харин сайнныг хай.“ - *Амос 5:14а*

“... Түүний ариун газарт хэн зогсож болох вэ? Цэвэр гартай, ариун зүрхтэй, хуурмаг байдалд сэтгэлээ өргөөгүй, худал тангараг тавиагүй хүн тэгэх юм“ - *Дуулал 24:3, 4*

## БУРХАНЫ ТУШААЛУУД

Шударгыг үйлд, энэрлийг хайрла,  
өөрийн Бурхантай хамт даруухнаар  
алх гэхээс өөр юуг Тэр чамаас  
шаарддаг вэ?

- *Мика 6:8б*

“Та нар ариун байгтун. Учир нь та  
нарын Бурхан ЭЗЭН Би бол ариун“

- *Левит 19:26*

“Чи өөрийн Бурхан ЭЗЭНээ бүх  
зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадал, бүх  
оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө  
өөрийн адил хайрла.“

- *Лук 10:27*

“Хүн бүү ал, бүү завхайр, бүү  
хулгайл, бүү худал гэрчил, бүү мэхэл,  
эцэг эхээ хүндэл гэсэн хуулиудыг чи  
мэднэ шүү дээ.“

- *Марк 10:19*

“Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн.  
Харин Бурханы хүсэл юу болохыг,  
тухайлбал сайн, тааламжит, төгс  
төгөлдөр хүслийг батлагтун.“

- *Ром 12:2*

“Хуулийн энэ номыг амнаасаа  
салгалгүй, харин түүндотор бичигдсэн  
бүхнийг сахин биелүүлэхээр өдөр  
шөнөгүй түүнийг бясалгаж яв. Тэгвэл  
чи хөгжин дэвжиж, амжилтад хүрэх  
болно.“

- *Иошуа 1:8*

“... Бурханд итгэгтүн.“

- *Марк 11:22б*

“Чи өөрийн Бурхан ЭЗЭНд  
үйлчил...“

- *Египт 23:25а*

## БУРХАНЫ ҮЗЭН ЯДДАГ ЗҮЙЛС

“ЭЗЭН доорх зургаан зүйлийг үзэн яддаг. ... Эдгээр нь гэвээс, Ихэмсэг харц, Худалч хэл, Гэм зэмгүй цусыг урсгагч гар, Хар буруу төлөвлөгөөг сэдэгч зүрх, Хорон муу уруу тургэн гүйгч хөл, Худал чалчдаг хуурамч гэрчлэгч болон, Ах дүүсийн дунд эвдрэлцлийг тараагч зэргүүд болой.“

- *Сургаалт үгс 6:16-19*

“... ЭЗЭН Би шударга ёсыг хайлаж, хүчээр дээрэмдэхийг үзэн яддаг...“

- *Исаа 61:8a*

“Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй

нуурт байна гэв.“

- *Илчэлт 21:8*

“... Тэр бурханлаг үр удмыг хайж байхад тэр нэгэн юу хийж байсан бэ? Тэгвэл сүнсэндээ анхаарал тавь. Хэн ч залуу насныхаа эхнэрийн эсрэг бүү тэрслэг. Учир нь Би салалтыг үзэн яддаг.“

- *Малахи 2:15б, 16а*

“Мөн та нарын нэг нь ч нөгөөгийнхөө эсрэг зүрхэндээ хорон муут бүү төлөвлө. Худал андгайд бүү дурла. Энэ бухэн нь Миний үзэн яддаг зүйлс юм.“

- *Зехариа 8:17*

“Гэвч Бурхан та нарын зүрхийг мэднэ. Яагаад гэвэл хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы өмнө жигшмээр юмс байдаг.“ - *Лук 16:15б*

## ХҮН БУРХАНЫ ШААРДЛАГАД ХҮРДЭГГҮЙ

“Харин та нарын дотор Бурханы хайр байхгүйг Би мэднэ.“

- *Иохан 5:42*

“Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр нь бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно.“ - *Иаков 2:10*

“Би сүйрсэн тул надад зовлон ирэг! Яагаад гэвэл би бузар уруултай хүн. Би бузар уруултай хүмүүсийн дунд амьдардаг. Учир нь миний нүд түмэн цэргийн ЭЗЭН болох Хааныг харлаа.“

- *Исаиа 6:5*

“Тийм учир зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм.“ - *Иаков 4:17*

“Энэ нь ингэж бичигдсэнчлэн Зөвт хүн алга. Ганц ч алга.“

- *Ром 3:10*

“Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.“

- *Ром 3:23*

“Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэгтүй аливаа хүн Бурханых биш.“

- *1 Иохан 3:10*

“Бид бүгдээрээ хонь мэт төөрч, Хүн бүр өөр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов.“

- *Исаиа 53:6*

“Энэ ариун Бурхан ЭЗЭНий өмнө хэн зогсож чадах вэ? Тэр Бурхан биднээс хэн уруу очих вэ?“

- *1 Самуел 6:20*

## БИД ҮЙЛСЭЭРЭЭ БУРХАНД ХҮРЭХГҮЙ

“Тэд Бурханы төлөө хичээл зүтгэлтэй боловч, энэ нь мэдлэгийн дагуу биш хэмээн би тэднийг гэрчилдэг. Учир нь Бурханы зөвт байдлыг мэдэлгүй, өөрсдийнхийгөө тогтоохыг эрмэлзэн тэд Бурханы зөвт байдалд үл захирагдав.“

- *Rom 10:2-3*

“Бид бүгдээрээ бузар нэгэн мэт болсон бөгөөд, бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг. Бид бүгдээрээ навч мэт хатаж, бидний нүгэл нь биднийг салхи мэт хийсгэнэ.“

- *Исаиа 64:6*

“Би зөвт хүнд түүнийг заавал амьдрана гэж айлдсан боловч тэрээр өөрийн зөвт байдалд хэт найдсаар хууль бусыг үйлдвээс түүний зөв

үйлсийн нэг нь ч дурсагдахгүй. Харин түүний үйлдсэн яг тийм хууль бус үйлдэл дотор тэр үхэх болно.“

- *Езекиел 33:13*

“Махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүй.“

- *Ром 8:8*

“Яагаад гэвэл ямар ч махан бие Хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Учир нь хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм.“

- *Ром 3:20*

“Бид ямар нэгэн юмыг өөрсдөөсөө гаргадаг юм шиг шаардаж чадахгүй. Харин бидний чадвар Бурханаас гардаг юм.“

- *2 Коринт 3:5*

“Хэн ч Бурханы өмнө хуулиар зөвтгөгддөгтүй гэдэг нь тодорхой. Яагаад гэвэл Зөвт хүн итгэлээр амьдарна.“

- *Галат 3:11*

## НҮГЭЛ БИДНИЙГ БУРХАНААС САЛГАДАГ

“Нэг хүнээр ертөнцдөн нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ.” - *Rom 5:12*

“Тэгээд хүсэл тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг. Нүгэл нь биеллээ олохоороо үхлийг авчирдаг аж.”

- *Иаков 1:15*

“Харин та нарын гэм буруу нь та нарыг Бурханаас хагацуулан, та нарын нүглүүд Бурханы нүүрийг та нараас далдалжээ. Тийм учраас Тэр сонсдоггүй.” - *Исаиа 59:2*

“Шударга зөвийг тууштай дагагч нь аминд хүрнэ. Хорон муут даган мөшгөгч нь өөрийн үхэл уруугаа тэмүүлнэ.” - *Сургаалт үгс 11:19*

Бурхан ийн айлдажээ. “Та нар

яагаад ЭЗЭНий тушаалуудыг зөрчин, амжилт олохгүй байна вэ? Та нар ЭЗЭНийг умартсан учраас Тэр бас та нарыг умартсан билээ.”

- *Шастрийн дэд 24:20*

“... Учир нь тэрслэх нь ид шидийн нүгэл адил, захирагдахгүй байх нь гэм ба шүтээнд мөргөхтэй адил билээ. Чи ЭЗЭНий үгнээс татгалзсан тул, ЭЗЭН бас чамайг хаан байлгахаас татгалзлаа.” - *1 Самуел 15:23*

“... Тэр цагт Би тэднээс заавал нүүрээ буруулна. Учир нь тэд өөр бурхдад урвана.” - *Дэд хууль 31:18*

... Нүглийг үйлдэгч нь үхэх болно. Хүү нь Эцэгийнхээ гэм буруугийн төлөөх шийтгэлийг үүрэхгүй, Эцэг нь ч Хүүгийнхээ гэм бурууг үүрэхгүй ...

- *Езекиел 18:20*

## БУРХАН НҮТЛИЙГ ҮЗЭН ЯДДАГ

“Бурхан бол шударга шүүгч бөгөөд  
Өдөр бүр хилэгнэдэг Бурхан юм.”

- *Дуулал 7:11*

“ЭЗЭН бол уурлахдаа удаан, хүч  
чадлаараа агуу ...”

- *Нахум 1:3a*

“Эдгээрээс болж Бурханы уур  
хилэн ирэх болно.”

- *Колоссай 3:6*

“Бурханы уур хилэн үнэнийг зөвт  
бусаар нуун дарагч хүмүүсийн аливаа  
бурханлаг бус ба зөвт бус байдлын  
эсрэг тэнгэрээс илчлэгддэг.”

- *Ром 1:18*

“Тэд бүхий л зөвт бус байдал, хорон  
муу, шунал, бузар булагыгаар дүүрэн,

атаа жетөө, аллага, хэрүүл, заль  
мэх, хар санаагаар дүүрэн байж, хов  
жив яригч, гүтгэгч, Бурханыг үзэн  
ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу,  
хорон мууг санаачлагч, эцэг эхдээ  
дуулгаваргүй, ухваргүй, найдваргүй,  
үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй  
хүмүүс ажээ. Ийм зүйлсийг үйлдэгч  
нь үхвэл зохино гэсэн Бурханы  
зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө  
үйлдээд зогсохгүй, харин ч бусдыг  
үйлдэхэд нь сайшаадаг ажээ.”

- *Ром 1:29-32*

“Бузар муут үйлдэгч хүн бүрийн  
дээр цөхрөл, зовлон байх болно.”

- *Ром 2:9a*

## ХОЖИМ ШҮҮЛТ ИРНЭ

“Нэг удаа үхэх нь Хүмүүст тогтоогдсон, үүний дараа нь шүүгдэнэ.“  
- *Еврей 9:27*

“Үхсэн их бага хүмүүс сэнтийн өмнө зогсож байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд, тэр нь амиин ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв. Хэрэв хэн нэгний нэр амиин номд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдсан байна.“

- *Илиялт 20:12, 15*

“Амьд Бурханы гарч орох нь аймшигтай хэрэг мөн“  
- *Еврей 10:31*

“Би та нарт хэлье. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно.“

- *Матай 12:36*

“Бурхан сайн, муу гэж ялгалгүй нууцлагдсан юмс бүрийг, бүх үйлсийг шүүлтэд аваачих болно.“

- *Номлогчийн үгс 12:14*

“Энэ үеийн төгсгөл ч мөн ийм байх болно. Тэнгэр элч нар ирж, зөвт хүмүүсийн дундаас муу хүмүүсийг ялгаж, тэднийг галтай зууханд хаяна. Тэнд тэд үйлж, шүдээ хавирах болно.“

- *Матай 13:49-50*

## БИД БУРХАНААС НУУГДАЖ ЧАДАХГҮЙ

“ЭЗЭНий мэлмий хaa ч байдаг ба  
Хорон муут хийгээд сайныг хардаг.“

- *Сургаалт үсэс 15:3*

“Өө, ЭЗЭН, Та намайг судлан,  
намайг мэдсэн билээ. Миний сууж  
босохыг ч хүртэл Та мэддэг юм. Та  
хаа холоос миний санаа бодлуудыг  
ойлгодог. Та миний явах зам мөр  
хийгээд хэвтэхийг минь ч нарийвчлан  
үзэж, Миний бүх явдлыг дотно сайн  
мэддэг. Намайг ганц үг өгүүлэхээс ч  
өмнө бүрэн мэддэг.“

- *Дуулал 139:1-4*

“... Түүний гаднах байдлыг болон  
нурууны өндрийг нь бүү харагтун.  
Би түүнийг үл тоов. Учир нь Бурхан  
хүнтэй адил хардагтүй. Хүн гаднах  
төрхийг хардаг бол ЭЗЭН зүрхийг нь

хардаг.“

- *1 Самуэл 16:7*

“Чихийг бүтээсэн Тэрээр сонсохгүй  
гэж үү? Нүдийг бүтээсэн Тэрээр  
харахгүй гэж үү?” - *Дуулал 94:9*

“Учир нь тэдний бүх замыг  
би хардаг. Тэд миний нүүрнээс  
нуугдаагүй, гэм буруу нь ч Миний  
мэлмийнээс далдлагдаагүй“

- *Иеремия 16:17*

“Түүний хараанаас нуугддаг нэг  
ч бүтээл байхгүй. Харин Түүний  
мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил  
болов. Түүнд бид тайлагнадаг.“

- *Евреи 4:13*

Гэм бурууг үйлдэгчид өөрсдийгөө  
нууж болохоор харанхуй, эсвэл гүн  
сүүдэр байдагтүй билээ. - *Иов 34:22*

## ГЭМИЙГ ХАЯХ ШААРДЛАГАТАЙ

Хорон муу хүнийг өөрийнхөө замаас эргэж, амьдрахаас нь илүүтээр түүний үхэлд Би баярлана гэж үү?

- *Езекиел 18:23*

“Үгүй, Би та нарт хэлье, Хэрэв гэмшихгүй бол та нар бүгд үүний адил мөхнө.”

- *Лук 13:3*

“Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтад хүрэхгүй. Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг мартдаг хүн хайр энэрлийг хүртэнэ.”

- *Сургаалт үгс 28:13*

ЭЗЭН тунхаглаж байна. “Харин одоо ч гэсэн мацаг барин, уйлан, гашуудаж, бүх зүрхээрээ Над уруу эргэгтүн! Та нар хувцсаа биш, харин зүрх сэтгэлээ тастан урагтун.”

- *Иоел 2:12, 13а*

“Өөртөө үгсийг аван ЭЗЭН уруу эргэ. Түүнд хандаж, Бүх гэм бурууг авч хаяад, биднийг нигүүлсэнгүйгээр хүлээн аваач!...”

- *Хосеа 14:2*

“Би нүгэл хийж, зөвийг үгүйсгэсэн бөгөөд энэ нь надад ханамжийг өгсөнгүй. Тэрээр миний сүнсийг нүхэнд унахаас зольсон бөгөөд миний амь гэрлийг үзнэ” гэх болно.

- *Иов 33:27, 28*

“Би та нарыг хүн бүрийнх нь байгаа байдлын дагуу шүүнэ гэж ЭЗЭН Бурхан тунхаглаж байна... гэмшиж, өөрсдийн бүх гэм буруугаас эргэ.”

- *Езекиел 18:30б*

## ГЭМШИЛ УУЧЛАЛД ХҮРГЭДЭГ

“Олдож болох үед нь ЭЗЭНийг хайгтун. Түүнийг ойр байгаа дээр нь дуудагтун! Хилэнцтэн нь өөрийн замаа, шударга бус хүн нь өөрийн бодол санаануудаа орхиод, Эзэн уруу эргэх болтугай. Түүнийг Тэр өрөвдөнө. Бидний Бурхан уруу эргэгтун. Учир нь Тэр өгөөмрөөр уучилна.”

- *Исаиа 55:6, 7*

“ЭЗЭН эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд Сүнсээрээ гэмшигчдийг авардаг.” - *Дуулал 34:18*

“Тэдэн дээр авчрах гэж Миний төлөвлөдөг бүх гай гамшгийг Иудагийн гэр сонсож магад. Ингэснээр хүн бүр өөрийн бузар муу замаасаа эргэх юм. Тэгэхэд Би тэдний гэм буруу болон тэдний

нүглийг уучилна” гэжээ.

- *Иеремиа 36:3*

“Би нүглээ Танд хүлээн хэлсэн бөгөөд гэм нүглээ нуугаагүй. Би ЭЗЭНд алдаа зөрчлөө хүлээнэ” гэж би хэлэв. Тэгээд Та миний нүглийн буруут уучилсан билээ. - *Дуулал 32:5*

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвэл, Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучиж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.

- *1 Иохан 1:9*

“Иймээс гэмшицгээ!” - *Үйлс 3:19a*

“Би Бурхан ЭЗЭНИЙ айлдахыг сонсоно. Учир нь Тэр Өөрийн ард түмэн буюу Өөрийн бурханлаг хүмүүст амар тайвныг айлдана.”

- *Дуулал 85:8*

## БУРХАНТАЙ ЭВЛЭРЭХИЙН ТУЛД БИДЭНД ЗОЛИОС ХЭРЭГТЭЙ

“Тэр хүний төлөө, өмнөөс нь энэ нь хүлээн авагдаж эвлэрүүлэхийн тулд тэр хүн гарса шатаалт тахилын толгой дээр тавина. Учир нь махан биенийн амь нь цусанд байдаг бөгөөд түүнийг Би та нарт өөрсдийн чинь амийн төлөө эвлэрүүлийг тахилын ширээн дээр хийхээр өгсөн юм. Учир нь цус бол амийн төлөө эвлэрүүлийг хийдэг юм.” -Левит 1:4, 17:11

“Хуулийн дагуу бараг бүх юм цусаар цэвэршүүлэгддэг бөгөөд цус урсахгүйгээр ямар ч уучлал байхгүй ажээ.” -Еөрөй 9:22

“Та нарын хурга өө сэвгүй, нэг настай эр хурга байх ёстой. Цус нь та нарын байгаа гэр дээр та нарын төлөө

тэмдэг болно.“

- Египетээс гарсан нь 12:5a, 13a

“Исаак эцэг Абрахамдаа хандан, “Аав минь ээ!” гэж дуудахад тэрээр, “Хүү минь, би энд байна.“ гэсэнд Исаак, “хараач, гал ба мод энд байна. Харин шатаалт, тахилын хурга нь хаана байна вэ?” гэхэд Абрахам, “Хүү минь, шатаалт тахилд зориулж Бурхан Өөрийгөө хургаар хангана“ гээд хоёул цааш явжээ. Абрахам хараагаа өргөн ажиглахад, нэгэн эр хонь өтгөн бутанд эврээрээ тээглэснийг харав. Абрахам очиж, тэр эр хонийг барьж аваад, хүүгийнхээ оронд түүнийг шатаалт тахил болгон өргөжээ.“

- Эхлэл 22:7, 8, 13

## ЕСҮС БОЛ БУРХАНЫ ДЭРГЭДЭХ ХУРГА

“Дараа өдөр нь Иохан өөр уруу нь ирж яваа Есүсийг хараад “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтуун!”  
- *Иохан 1:29*

“Бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаарбидэлгэрсэн. Тэртамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хетлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй.”

- *Исаиа 53:56, 7*

“Тэр ямаа болоод тугалын цусаар бус, харин мөнхийн золилтыг агуулан, Өөрийнхөө цусаар ариун газарт нэг удаа бүгдийн төлөө орсон. Харин эдүгээ, үеийн төгсгөлд Өөрийгөө тахил болгон нүглийг зайлцуулахын

тулд Тэр нэг удаа үзэгдсэн юм. Тийнхүү Христ мөн олны нүглүүдийг үүрэхийн тулд нэг удаа өргөгдсөн.”

- *Еврей 9:12, 26б, 28а*

“Ингэхдээ та нар эцэг өвгөдөөсөө өвлөсөн өөрсдийн утгагүй амьдралаас алт, мөнгө мэтийн устах зүйлсээр золигдсон бус, харин үнэт цусаар, Христийн цус болох гэм зэмгүй бөгөөд толбогүй хурганы цусаар золигдсон гэдгээ мэдэгтүн.”

- *1 Петр 1:18а, 19*

“Тэгэх тусмаа мөнх сүнсээр гэмгүй Өөрийгөө Бурханд өргөсөн Христийн цус нь бидний мөс чанарыг үхсэн үйлсээс цэвэрлэн, амьд Бурханд үйлчлүүлиэ шүү дээ!”

- *Еврей 9:14*

## ЗӨВХӨН БУРХАН ТӨЛӨӨСИЙГ ТӨЛСӨН

“Харин Христ Есүс доторх золилтоор дамжуулан Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн билээ. Түүний цусанд итгэх итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг эвлэрүүлэл гэж нийтэд харуулав.“

- *Rom 3:24, 25a*

“Гэвч биднийг нүгэлтийүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно.“

- *Rom 5:8, 9*

“Гэсэн хэдий ч хүн Хуулийн үйлсээр бус, харин Христ Есүст итгэх итгэлээр зөвтгөгддөг гэдгийг мэнднэ.“

- *Галат 2:16a*

“Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.“

- *Ефес 2:8, 9*

“Түүнд итгэсэн хэн боловч Түүний нэрээр нүглийн уччлалыг хүлээн авдаг гэж бүх эш үзүүлэгчид Түүнийг гэрчилдэг.“

- *Үйлс 10:43*

“Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй.“

- *Үйлс 4:12*

“Түүний нигүүлслийн баялгийн дагуу Түүний дотор цусаар нь золилт, гэм нүглийн маань төлөөх уччлал бидэнд байдаг.“

- *Ефес 1:7*

## ЕСУСИЙН МЭНДЭЛСНИЙГ ТУНХАГЛАСАН

“Тэнгэр элч Габриэлыг Бурхан Галилын Назар хот уруу зургадугаар сард илгээсэн ажээ. Габриэл Давидын удмын Иосеф гэдэг хүнтэй сүй тавьсан онгон бүсгүйн гэрт хүрч ирлээ. Түүнийг Мария гэдэг байв. Орж ирээд тэнгэр элч түүнд: “Ивээгдэгч ээ, баярла! Эзэн чамтай хамт байна” гэв. Харин Мария энэ үгэнд ихэд цочиж, энэ нь юун мэндчилгээ байж болох талаар бодож цэгнэв. Тэнгэрэлч түүнд: “Мария бүү ай. Чи Бурханы ивээлийг олжээ. Үзэгтүн, чи хэвлэйдээ үртэй болж хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. Тэр Хүү агуу Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана. ЭЗЭН Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно.

Тэр Иаковын гэрийг үүрд хаанчлах бөгөөд Түүний хаанчлалд төгсгөл байхгүй байна” гэсэнд, Мария тэнгэр элчид, “Би онгон атал энэ нь яаж бүтэх билээ?” гэхэд тэнгэр элч, “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно. Үзэгтүн, чиний садан Элизабет мөн өтөл насандаа хүүтэй болж, хүүсэр гэгдэж байсан тэр эмэгтэй одоо зургаан сартай. Учир нь Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” гэж хэлэв. Мария, “Эзэний шивэгчнийг харагтуун. Хэлсэн угсийн тань дагуу надад биелэх болтугай гэхэд нь тэнгэр элч түүнийг орхин одлоо.”

-Лук 1:26а-38

## ЕСҮС ГЭЖ ХЭН БЭ?

“Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанаараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоослож, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов.“

- *Филиппий 2:5-8*

“Би болон Эцэг нэг юм гэж айлдлаа. Эцэгийн ариусгасан, ертөнцөд илгээсэн Нэгэнийг “Би Бурханы Хүү байна“ гэснээс болж та нар “Та Бурханыг доромжлогч“ гэж хэлж байна уу?”

- *Иохан 10:30, 36*

Есүс Христ, Мөнхийн Үг, мөнхөд байсан. Бурхан Түүнийг ер бусын аргаар Марийн хэвлийд бүрэлдүүлжээ. Хувь хүний хувьд Хүний Хүү, сүнсний хувьд Бурханы Хүү гэж алдаршжээ. Бурхан болоод Түүний Үг Есүс Христийн хоорондох харилцааг тайлбарлахын тулд (Хүү гэж Библид байдаг)

“Тиймээс Тэр ертөнцөд ирэхдээ “Та өргөл ба тахилыг хүсээгүй, Харин Та Надад бие бэлдсэн.“

- *Еврей 10:5*

“Ариун байдлын Сүнсээр үхэгсдээс амилуулагдсанаар хүч дотор Бурханы Хүү гэж тодорхойлогдсон бидний Эзэн Есүс Христ мөн.“

- *Ром 1:4*

## ЕСҮС ГЭЖ ХЭН БЭ?

“Бурханлаг байдлын нууц нь агуу гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрнө.

Махан биеэр илчлэгдсэн Тэр нь Сүнс дотор зөвтгөгдсөн, Тэнгэр элч наарт харагдсан.”

- *Тимот 3:16а*

“Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог.”

- *Колоссаи 2:9*

“Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна.”

- *Исаиа 9:6*

“Үнэнээр, үнэнээр Би та наарт хэлье.

Абрахамыг бий болгохоос өмнө Би байдаг мөн гэж айлдав.“

- *Иохан 8:58*

“Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. Ертөнцөд ирсэн хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв. Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй.“

- *Иохан 1:4, 9-10*

“Учир нь Ганц Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ. Тэр Өөрийгөө бүгдийн төлөө золиос болгон өгсөн.“

- *1 Тимот 2:5, 6а*

## БИБЛИ (БИЧЭЭС) БОЛ БУРХАНЫ ҮГ

“Учир нь нэг ч эш үзүүллэг хэзээ ч хүний хүслээр хийгдсэнгүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлдажээ.“

- 2 Петр 1:21

(Тэр эртнээс ариун эш үзүүлэгчдийнхээ амаар дамжуулан айлдсанчлан) Энэ нь Түүний ард түмэнд авралын мэдлэгийг нүглүүдийнх нь уучлалаар өгөхийн тулд юм”

- Лук 1:70, 77

“ЭЗЭНий Сүнс надаар дамжуулан айлдав. Түүний үт миний хэлэн дээр буй.“

- 2 Самуел 23:2

“Өнөөдөр Миний чамд тушааж байгаа энэ үгсийг чи зүрхэндээ байлгага.“

- Дэд хууль 6:6

“Судар бүр Бурханы амьсгалнаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай.“

- 2 Тимот 3:16

“Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм. Ингэснээр Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм.“

- Ром 15:4

“Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээс болж төөрөлдөж байна.“

- Матаи 22:29

“Таны хайр энэрэл, үнэний тань төлөө Таны нэрд талархал өргөнө.“

- Дуулал 138:26

## ЕСҮС БОЛ БУРХАНЫ ҮГ

“Тэр цусанд дүрэгдсэн дээл өмсжээ. Түүний нэрийг “Бурханы Үг” гэдэг ажээ.”

- *Илчлэлт 19:13*

“Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан.”

- *Иохан 1:1, 14а*

“Бурханыг хэн ч хэзээ ч хараагүй бөгөөд Эцэгийн өвөр дэх цорын ганц Хүү болох Бурхан нь Түүнийг таниулсан юм.”

- *Иохан 1:18*

“Яагаад гэвэл “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн нүүрэн дэх Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр

бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн мөн.”

- *2 Коринт 4:6*

### Бурхан Хүүгээрээ ярьдаг

“Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз бүрийн арга замаар айлдсан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бүхний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ”

- *Еөрөй 1:1, 2*

“Намайг хайрладаггүй хүн Миний үгийг сахьдагтүй. Та нарын сонсож байгаа үг Минийх биш, харин Намайг илгээсэн Эцэгийнх билээ.”

- *Иохан 14:24*

## БИЧМЭЛ БА АМЬД УГИЙН ХАРЫЦУУЛАЛТ

### Библи бол сүнсний хоол

“Би Түүний амнаас гардаг үгсийг өөрт минь хэрэгтэй хоолноос ч илүүгээр нандигнасан...”

- *Иов 23:12б*

“Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна” гэж бичигдсэн байдаг.

- *Матай 4:4б*

### Есүс бол тэнгэрийн талх

Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ергэнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махран бие юм гэж айлдлаа.

- *Иохан 6:51*

### Библи бол зам дахь гэрэл

“Таны үг бол миний хөл дэх дэнлүү,  
Миний зам дахь гэрэл юм.”

- *Дуулал 119:105*

“Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг. Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарлыг хайлрадаг.”

- *Дуулал 119:130*

### Есүс бол дэлхийг гийгүүлэгч

“Түүнд амь байсан бөгөөд, амь нь хүмүүсийн гэрэл байв.”

- *Иохан 1:4, 8, 12*

## **Библи амжилттай амьдралыг авчирдаг**

“Харин тэрээр ЭЗЭНий хуульд баярлаж, Түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бясалгадаг. Тэрээр урсгал усны дэргэд тарьсан мод адил билээ. Тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд Навчис нь ч хатдаггүй. Тэр хүний үйлс бүхэн нь өлзийтэй.”

-Дуулал 1:2, 3

Есүсийн өгөх амжилттай амьдрал

“Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрууд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй”

-Иохан 15:4, 5

## **ЕСҮС ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ**

“Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ. Хэрэв та нар Мосед итгэсэн бол Надад итгэх байсан. Учир

нь тэр Миний тухай бичсэн юм.”

-Иохан 5:39, 46

“Тэгээд Тэр Мосегээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав.”

-Лук 24:27

## БУРХАНЫ МӨНХ ҮГ ХЭЗЭЭ Ч ӨӨРЧЛӨГДӨХГҮЙ

“Өө, Эзэн, Таны үг тэнгэрт Мөнхөд бат тогтдог.“

- *Дуулал 119:89*

“Таны үгийн нийлбэр нь үнэн бөгөөд Таны зөв шударга тогтоол бүхэн нь мөнхийнх юм.“

- *Дуулал 119:160*

“Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно.“

- *Исаиа 40:8*

Үнэнээр Би та нарт хэлье, тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй.

- *Матай 5:18*

“Судар нь зөрчигдөхгүй“

- *Иохан 10:35*

***Хүн Бурханы үтийг өөрчилж зүрхэлнэ гэж үү!***

“Миний та нарт тушаасан болгоныг та нар дагаж мөрдөж, түүн дээр бүү нэм, бүү хас.“

- *Дэд хууль 12:32*

“Түүний үгэн дээр бүү нэм. Тэгвээс Тэр чамайг буруутгаж, чи худалч болох вий.“ - *Сургаалт үгс 30:6*

“Хэрэв хэн нэгэн нь энэхүү эш үзүүлэгийн номын үгсээс хасах аваас Бурхан энэхүү номонд бичигдсэн амийн модноос болон ариун хотоос хувийг нь хасах болно.“

- *Илчлэлт 22:19*

“Үгийг үл тоомсорлогч нэгэн өөрийгөө өрөнд унагаж буй хэрэг.“

- *Сургаалт үгс 13:13а*

## ТҮҮНИЙ УХЭЛ БУРХАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ БИЕЛҮҮЛСЭН

“Тиймээс Эцэг Намайг хайлрадаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө. Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин би Өөрийн санаагаар Түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий. Энэ тушаалтыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм.“

- *Иохан 10:17, 18*

Есүс түүнд “Танд дээрээс эрх мэдэл өгөгдөөгүй л бол, Миний эсрэг байх ямар ч эрх мэдэл баймааргүйсэн.“

- *Иохан 19:11a*

“12 легионоос олон тэнгэр элчийг одоохон Өөр уруугаа илгээхээр Би Эцэгээс гуйж чадахгүй гэж чи бодож байна уу? Тэгвэл энэ нь болох ёстой гэсэн Судар яаж биелэгдэх билээ?”

- *Матай 26:53, 54*

“Өөрийнх нь Христ зовж тарчлах ёстай гэж Бурхан бүх эш үзүүлэгчдийн амаар урьдаас тунхаглуулсан зүйлсээ Тэр тийнхүү хэрэгжүүлэв.“

- *Үйлс 3:18*

“Бурханы урьдаас мэдэх мэдлэг болон урьдаас тогтоосон төлөвлөгөөний дагуу тушаагдсан энэ Хүнийг та нар бурхангүй хүмүүсийн гараар загалмайд хадуулж, алсан.“

- *Үйлс 2:23*

“Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь Эзэний таалал байв...“

- *Исаиа 53:10a*

“Христ энэ бүх зовлонг эдлэн, Өөрийн сүр жавхланд орох ёстай байсан биш үү? гэв.“

- *Лук 24:26*

## ЕСҮСИЙН ҮХЛИЙГ ГЭРЧЛЭГСЭД

“Цэргүүд Есүстэй хамт хоёр дээрэмчнийг, нэгийг нь баруун талд нь нөгөөг нь зүүн талд нь цовдолжээ. Тэр хилэнцэтнүүдийн хамт тоологдсон гэсэн судар биелэгдэв.“

- *Марк 15:27, 28*

“Цэргүүд ирж, Есүстэй хамт цовдлогдсон эхний хүний болон нөгөө хүнийх нь хөлийг хугалав. Харин Есүс уруу ирээд Түүний хэдийнээ үхсэн байхыг тэд үзээд, хөлийг нь хугалсангүй. Цэргүүдийн нэг нь хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо. Харсан хүн үүнийг гэрчлэв. Түүний гэрчлэл нь үнэн бөгөөд та нарыг ч мөн итгүүлэхийн тулд үнэн ярьдаг гэдгээ тэр мэднэ. Судрын

“Түүний нэг ч яс хугалагдахгүй“ гэсэн нь биелэгдэхийн тулд эдгээр нь болжээ.“Тэд жадалсан Хүн уруугаа харах болно“ гэж мөн өөр Сударт хэлдэг.“

- *Иохан 19:32-37*

“Зургадугаар цагаас есдүгээр цаг хүртэл бүх газрыг харанхуй нөмрөн авлаа. Есүс дахин чангаар хашкираад Θөрийн сүнсээ гаргажээ. Үзэгтүн, сумийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон цуу урагдаж, газар хөдлөн, хад чулуу бут хагаран, Есүсийг харгалзаж байсан зуутын дарга болон харуулууд газар хөдлөлт болон болж буй бүхнийг хараад ихэд айн, “Үнэхээр энэ хүн Бурханы Хүү байжээ“ гэв.

- *Матаи 27:45, 50-51, 54*

## ЕСҮС ҮХЛИЙГ ЯЛСАН

“Гэтэл Бурхан үхлийн зовлонг эцэс болгон Түүнийг амилуулав. Учир нь Түүний хувьд үхлийн хүчинд автагдах нь боломжгүй юм. Энэ Есүсийг Бурхан амилуулсан бөгөөд бид бүгдээрээ үүний гэрч нар мөн.“

- *Үйлс 2:24, 32*

“Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр Өөрөөбас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм.“

- *Еөрөй 2:14-15*

“Үхэл ээ, чиний ялалт хаана байна вэ? Үхэл ээ, чиний хатгуур хаана байна вэ? Харин бидний Эзэн Есүс

Христээр бидэнд ялалтыг өгдөг Бурханд талархал нь байх болтугай.“  
- *1 Кор 15:55, 57*

“Амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун, Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр бий.“

- *Илчлэлт 1:18*

“Харин Бурханы хүчээр сайн мэдээний төлөө зовлон дотор надтай холбогд. Харин эдүгээ энэ нь бидний Аврагч Христ Есүсийн үзэгдсэнээр илчлэгджээ. Тэр үхлийг устган, амь ба үхэшгүй байдлыг сайн мэдээгээр дамжуулан гэрэлд авчирсан.”

- *2 Тимот 1:86, 10*

“Үхэл цаашид Түүнийг захирагчай“  
- *Ром 6:9б*

## БИД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

“Харагтун, би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.“

- *Илчлэлт 3:20*

Харин ажил хийдэггүй боловч, бурханлаг бус хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний хувьд итгэл нь зөвд тооцогддог.

- *Ром 4:5*

“Ариун сүнсийг хүлээн авагтун. Та нарын баяр баясгалан дүүрэн болгогдохын тулд та нар хүлээн авна.“

- *Йохан 20:226, 16:24б*

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвлөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэн дээ итгэвэл аврагдах болно.

- *Ром 10:9*

“Эцгийгээ эсвэл эхийгээ Надаас илүү хайрладаг хүн Миний хувьд зохицой нэгэн биш юм. Тэгээд Есүс шавь нартаа “Хэрэв хэн нэг нь Миний араас явахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэг. Загалмайгаа үүрч, Намайг дагаг. Учир нь хэн өөрийнхөө амийг аврахыг хүснэ, тэр хүн түүнийгээ алдана. Харин хэн миний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ олно.“

- *Матай 10:37а, 16:24-25*

“Хэрэв та нар Христийнх юм бол та нар Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжлагчид мөн“

- *Галат 3:29*

“ЭЗЭН Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана.“

- *Үйлс 16,31*

## БИД ЕСҮСЭЭР ДАМЖИН ШИНЭ АМИЙГ ОЛДОГ

“Гэрчлэл нь энэ байна. Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд, энэхүү амь нь түүний Хүүгийн дотор байна. Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй.“

- *1 Иоан 5:11, 12*

“Харин Бурхан өршөөлөөр баян ажээ. Тэр биднийг хайлласан Өөрийн агуу хайраараа биднийг гэм нүгэл дотроо үхсэн байхад Христтэй хамт амьд болгосон юм. Та нар нигүүлслээр аврагдсан билээ.“

- *Ефес 2:4, 5*

“Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махран биендээ амьд байгаа нь... Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм.“

- *Галат 2:20*

“Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нутглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн билээ.“

- *Ром 8:2*

“Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтуун, шинэ болсон байна“

- *2 Коринт 5:17*

Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дамжуулан дахин төрсөн билээ.

- *1 Петр 1:23*

“Үгийн цэвэр сүүг нялх хүүхдүүд адил хүсэн тэмүүл. Ингэснээр та нар үүгээр авралд хүртлээ өсөх юм.“

- *1 Петр 2:2*

## БУРХАН БОЛ ӨӨРИЙН ХҮМҮУСИЙН ЭЦЭГ

Эцэгтүй хүний эцэг нь, бэлэвсний шүүгч нь бол Өөрийн ариун газартаа буй Бурхан юм.

-Дуулал 68:5

“Гэвч эдүгээ ЭЗЭН, Та бол бидний Эцэг билээ. Бид шавар, Та бол бидний Ваарчин. Бид бүгдээрээ Таны мутрын бүтээл. Өө, ЭЗЭН, Та бидний Эцэг. Эртнээс Таны нэр бол бидний Аврагч.”

-Исаа 64:8, 63:16б

“Та нар миний ард түмэн биш” хэмээн тэдэнд хэлсэн газарт “Та нар амьд Бурханы хөвгүүд” хэмээн тэдэнд хэлэх болно.

-Хосеа 1:10б

“Хэрэв та нар бузар атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө

мэддэг юм бол тэнгэр дэх Эцэг тань Өөрөөс нь гүйдаг хүмүүст илүү сайныг өгөх нь дамжигтүй бус уу? Тиймд ийнхүү залбир. “Тэнгэрт байгаа бидний ЭЦЭГ минь, Таны нэр ариунаар дуурсгагдаг.”

-Матай 7:11, 6:9

“Бузар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, Та нарын Эцэг чинь болно. Та нар ч Миний хөвгүүд, охид минь болно” гэж Төгс хүчит ЭЗЭН айлддаг.”

-2 Коринт 6:17б, 18

“Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм.”

-Ром 8:14

## ЕСҮСЭЭР ДАМЖИН БУРХАНЫГ ААВ ГЭДЭГ

Есүс “Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй. Хэрэв та нар Намайг мэдсэн бол Миний Эцэгийг ч мөн мэдэх байсан. Одооноос эхлэн та нар Түүнийг мэдэж, Түүнийг харлаа.“

“Миний Эцэг түүнийг хайрлана. Бид тэр хүн уруу очиж, Түүнтэй хамт Өөрсдийн орон байраа байгуулна.“

- *Иохан 14:6, 7, 23б*

“Харин цаг нь болоход Бурхан эмэгтэй хүнээс Хуулийн дор төрөх Өөрийн Хүүгээ илгээсэн юм. Энэ нь Хуулийн дор байгсыг золихын тулд юм. Ингэснээр бид хөвгүүд нь адил үрчлэлийг авах юм.“

Тиймээс чи цаашид боол биш, харин хүү нь мөн. Хэрэв хүү нь байх

аваас Бурханаар дамжуулан өв залгамжлагч нь мөн байна. Учир нь та нар бүгд Христ Есүст итгэх итгэлээр Бурханы хөвгүүд болсон ажээ.”

- *Галат 4:4, 5, 7, 3:26*

“Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.“

- *Иохан 1:12*

“Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн.“

- *1 Иохан 2:16*

“Тиймээс бид цемөөрөө нэг Сүнс дотор Христээр дамжуулан Эцэг уруу очих замтай болжээ.“

- *Ефес 2:18*

## ЕСҮС ХАЙР, БАЯР, АМАР АМГАЛАНГ АВЧИРДАГ

“Хайрладагтүй нэгэн нь Бурханыг мэддэгтүй. Учир нь Бурхан бол хайр билээ. Хайрын дотор байгч нэгэн нь Бурхан дотор байж, Бурхан түүний дотор байна.“ - *Иохан 4:8, 16б*

“Бурхан та нарыг Христ дотор уччилсны адил бие биенээ уччлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөвлөн сэтгэлээр ханд.“ - *Ефес 4:32*

“Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол, үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно.“ - *Иохан 13:35*

“Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм.“ - *Галат 5:22, 23а*

“Би ЭЗЭНий дотор баясан хөөрч,

авралынхаа Бурхан дотор баярлана.“  
- *Хабаккук 3:18*

“Та надад амийн замыг таниулна. Таны өмне л баяр хөөр дуурэн байдаг. Таны баруун мутарт үүрд баяр жаргал байдаг.“ - *Дуулал 16:11*

“Тиймээс итгэлээр зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай эвлэрсэн билээ.“

- *Ром 5:1*

“Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.“ - *Иохан 14:27*

“Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх бодлыг тань хамгаална.“ - *Филиппой 4:7*

## ЕСҮС ӨӨРИЙН ДАГАЛДАГЧИДАА АМИЛУУЛНА

Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжуулан үхлийн биест чинь амь өгнө.

- Ром 8:11

“Бурхан зөвхөн Эзэнийг амилуулсан төдийгүй биднийг ч бас Өөрийн хүчээрээ амилуулна.“

- 1 Коринф 6:14

“Учир нь Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Миний Эцэгийн хүсэл юм. Эцсийн өдөрт Би Өөрөө Түүнийг амилуулна“ гэж айлдлаа. - Иохан 6:40

“Есүс Мартгад “Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч

амьдарна. Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй.“

- Иохан 11:25, 26а

“Учир нь үхэл нь нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилалт нь мөн нэг хүнээр иржээ. Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно. Харин тус бүр Өөрийн дараалал дотор байна. Христ бол анхны үр жимс юм. Дараа нь Христийн хүмүүс Түүнийг ирэхэд амилуулагдана.“ - 1 Кор 15:21-23

“Харин та нар Намайг харна. Яагаад гэвэл Би амьд байна. Та нар ч амьд байна.“ - Иохан 14:19б

“Хэрэв бид Христтэй хамт үхсэн бол, мөн Түүнтэй хамт амьдрах болно гэдэгтээ бид итгэдэг.“ - Ром 6:8

## ЭНЭХҮҮ АГУУ АВРАЛЫГ БҮҮ ҮЛ ТООМСОРЛО

“Мосгийн хуулийг үл хэрэгсэгч хүн хоёр буюу гурван хүний гэрчлэлийн үгээр өршөөлгүй үхнэ. Бурханы Хүүг уландаа гишгэж, Өөрийг нь ариутгасан Гэрээний цусыг ариун бусаар үзээд, Ивээлийн Сүнсийг доромжилсон хүн хир зэрэг хүнд шийтгэл эдэлвэл зохихыг та нар бодоод үз.“

“Намайг голж, Миний үгийг хүлээж авдагтүй хүнийг шүүх шүүгч бий. Миний хэлсэн үг эцсийн өдөрт түүнийг шүүнэ.“

- *Иохан 12:48*

“Тиймээс Би “Та нар нүглийнхээ дотор үхнэ“ гэж та нарт хэлсэн. Учир нь хэрэв та нар “Би байдал“ гэдэгт итгэхгүй бол нүглийнхээ дотор

үхнэ.“

- *Иохан 8:24*

“Би та нарт хэлье. Андууд минь, биеийг хөнөөгсдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. Харин хэнээс аиж эмээвэл зохихыг та нарт сануулъя. Хөнөөсний дараа тамд хаях эрх мэдэлтэй Нэгэнээс аиж эмээгтүн. Тиймээ, Би та нарт хэлье, Түүнээс айгтун.“

- *Лук 12:45*

“Бид тийм агуу авралыг үл хайхраад хэрхэн зугтаах билээ?“

- *Евреи 2:3a*

“Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдал.“

- *Иохан 3:36b*

## ЕСҮС ХРИСТ БИДНИЙГ ШҮҮНЭ

“Өөрийнхөө томилсон нэгэн Хүнээр дамжуулж өртөнцийг шударгаар шүүх өдрөө Тэр тогтоосон агаад тэр Хүнийг үхэгсдээс амилуулснаар үүнийгээ бүх хүмүүст нотолсон ажгуу.“

- *Үйлс 17:31*

“Учир нь Эцэг хэнийг ч шүүхгүй. Харин Тэр бүх шүүлтийг Хүүдээ даатгасан. Энэ нь бүгд Эцэгийг хүндэлдгийн адил Хүүг хүндлэхийн тулд юм. Хүүг хүндэлдэгтүй хүн Түүнийг илгээсэн Эцэгийг хүндэлдэггүй.“ - *Иохан 5:22-23*

“Учир нь хүн бүр мууг ч бай, сайныг ч бай, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахын тулд бид бүгдээрээ Христийн шүүхийн суудлын өмнө гарч ирэх ёстой.“ - *2 Коринт 5:10*

“Миний сайн мэдээний дагуу, энэ нь Бурхан хүмүүсийн нууц зүйлсийг Христ Есүсээр шүүх өдөрт болно.“

- *Ром 2:16*

“Тэр үед Эзэн Есүс хүчирхэг тэнгэр элч нарынхаа хамт дүрэлзэх гал дотор тэнгэрээс илчлэгдэн, Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайн мэдээг дагадагтүй хүмүүсээс өшөө авах ажээ.“

- *2 Тесалоник 1:76, 8*

“Надаар өөрсдийгөө хаанчуулахыг хүсээгүй Миний дайснуудыг нааш авчирч, Миний өмнө тэднийг хөнөөгтүн гэж зарлиг буулгажээ.“

- *Лук 19:27*

## ИТГЭГЧ ГЭСЭН БОЛГОН ЖИНХЭНЭ ИТГЭГЧ БИШ

“Тэд Бурханыг мэднэ гэж шууд хүлээн зөвшөөрдөг атлаа ... үйлсээрээ үгүйсгэдэг.”

- *Тим 1:16а*

“Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш.”

- *Ром 8:9б*

“Гэвч тэд түүнийг үйлдэхгүй. Учир нь тэд өөрсдийн амаар гаргасан тачаангуй хүслүүдээ үйлдэж, тэдний зүрх нь олз ашгийнхаа араас явдаг.”

- *Езекиел 33:31б*

“Энэ ард түмэн Намайг амаараа хүндэлдэг. Гэвч тэдний зүрх Надаас алс хол байдаг.”

- *Матай 15:8*

“Намайг Эзэн минь, Эзэн минь гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд

орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. Тэр өдөр Надад олон хүн, “Эзэн минь, Эзэн минь бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшигуудыг үзүүлж байсан биш бил үү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд, “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.”

- *Матай 7:21-23*

“Та нар ч гэсэн хүмүүсийн өмнө гаднаа зөвт хүмүүс мэт харагдавч, дотроо хоёр нүүрт зан болон хууль бус явдлаар дүүрэн аж.”

- *Матай 23:28*

## ЖИНХЭНЭ ИТГЭГЧИД ЕСУСИЙГ ДАГАДАГ

“Хэрэв бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэнднэ.” - *1 Иохан 2:3*

“Би өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихыг анхаарах болно.”

- *Езекиел 36:27*

“Нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон.” - *Ром 6:18*

“Олон хөвгүүдийг алдар уруу авчрахдаатэдний авралын Зохиогчийг нь зовлонгоор дамжуулан төгс болгох нь Түүнд зохистой байжээ. Бүх юмс Түүний төлөө бөгөөд Түүгээр бүх юмс байдаг.”

- *Ефреј 2:10*

“Хэрэв Христ та нарын дотор байгаа бол, нүглээс болж бие нь үхмэл хэдий ч, зөвт байдлын улмаас сүнс нь амьд байна. Учир нь хэрэв та нар махан биенийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биенийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно.”

- *Ром 8:10, 13*

“Энэ нь “Эзэн Өөрийн хүмүүсийг таньдаг”, “Эзэний нэрийг нэрлэгч хүн бүр муу явдлаас хол байгтун” гэсэн тамгатай.”

- *2 Тимот 2:19б*

“Харин Петр болон бусад элч нар тэдэнд, Бид хүнийг дагахаасаа илүү Бурханыг дагах ёстой.”

- *Үйлс 5:29*

## ДЭЛХИЙ ЕСУСИЙН ШАВЬ НАРЫГ ҮЗЭН ЯДДАГ

“Хэрэв ертөнц та нарыг үзэн ядвал, та нараас өмнө Намайг үзэн ядсаныг нь мэдэгтүн. Хэрэв та нар ертөнцийнх байсан бол, ертөнц өөрийнхнийгөө хайллахсан. Харин та нар ертөнцийнх биш, гагцхүү Би та нарыг ертөнцөөс сонгосон юм. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг.“

- *Иохан 15:18, 19*

“Харин та нарыг алах хүн бүр өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж бодох цаг ирж байна. Тэд Эцэгийг болон Намайг мэдээгүй учраас тийм юм хийх болно.“

- *Иохан 16:26, 3*

“Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач! Бид бол

тийм юм. Иймээс ертөнц Түүнийг мэдээгүй тул биднийг мэддэггүй.“

- *Иохан 3:1*

“Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой гэлээ.“

- *Үйлс 14:226*

“Үнэндээ, Христ Есүс дотор бурханлаг амьдрахыг хүсэгч бүх хүмүүс хавчигдах болно.“

- *2 Тимот 3:12*

“Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа...“

- *Иохан 16:33б*

“Би Таны үгийг тэдэнд өгсөн. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш тул ертөнц тэднийг үзэн ядсан юм.“

- *Иохан 17:14*

## ЗОВЛОНГ ЭДЛЭГСДЭД ӨГӨГДСӨН АМЛАЛТУУД

“Тэр та нарын төлөө санаа зовдог учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл.“

- 1 Петр 5:7

“Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар бүү санаа зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална. Би заавал Өөрийн зөв баруун мутраар чамайг хамгаална.“

- Исаа 41:10

“Миний эцэг, эх намайг орхисон, Харин Эзэн намайг босгоно.“

- Дуулал 27:10

“Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч мөн. Би айхгүй. Хүн намайг яах юм бэ?” гэдэг.

- Еврей 13:6

“Хэрэв та нар Христийн нэрээс болж зүхэгдвэл өрөөлтэй.“

- 1 Петр 4:14а

“Учир нь бүх замд чамайг хамгаалахын тулд Тэр Өөрийн тэнгэр элч нарт чиний талаар тушаал өгнө.“

- Дуулал 91:11

“Үхлийн харанхуй хөндийгөөр туулавч, Би хор хөнөөлөөс айхгүй, Учир нь Та надтай хамт байна. Таны саваа, Таны таяг, намайг тайвшируулдаг.“

- Дуулал 23:4

“Надад хүчийг өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна. Миний Бурхан Өөрийн алдар дахь баялгаар Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана.“

- Филиппий 4:13, 19

## ГЭМ БА САТАНЫГ ЯЛСАН НЬ

“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, Харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм.”

- *1 Коринт 10:13*

“Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очьё.”

- *Ереi 4:16*

“Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нутглээс ангижруулдаг ажээ...” - *1 Иохан 1:7*

“Идэр насыхаа дур хүслүүдээс зугт. Харин цэвэр зүрх сэтгэлээс Эзэнийг дуудагчдын хамт зөвт байдал, итгэл, хайр ба амар тайвныг мөрдөгтүн.” - *2 Тимот 2:22*

“Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа гэж тооц.”

- *Ром 6:11*

“Тиймээс Бурханд захирагдагтун Диаволыг эсэргүүц, тэгвэл тэр та нараас зайлна.” - *Иаков 4:7*

“Таны эсрэг нүтгэл хийхгүйн тулд, Таны үгийг би зүрхэндээ хадгалсан.” - *Дуулал 119:11*

“Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу.” - *1 Иохан 4:46*

## ҮНЭН ЗАЛБИРАЛ-БУРХАНТАЙ НӨХӨРЛӨХ

Та “Миний царайг эрэн хайгтун” гэхэд Миний зүрх Танд “ЭЗЭН, Таны царайг эрж хайх ёстой” гэж хэлжээ... Хүмүүсээ, хэзээд Түүнд итгэ! Түүний өмнө зүрхээ нээ. Бурхан бидэнд хоргодох газар юм.”

- *Дуулал 27:8, 62:8*

Намайг эдгээгээч, Θε ΕΣΣΗΝ, би эдгэх болно. Намайг авраач, би аврагдах болно, Учир нь Та бол миний магтаал юм.”

- *Иеремия 17:14*

“Тасралтгүй залбир. Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.”

- *1 Тесалоник 5:17, 18*

“Харин та нарын хэн нэг нь мэргэн

ухаанаар дутвал бүх хүнд өгөөмрөөр буруушаалгүй өгөгч Бурханаас гуй.”

- *Иаков 1:5*

“Хэрэв хэн нэг нь Миний дотор байхгүй бол мечир мэт хаягдаж, хувхайрна. Хүмүүс тэдгээр мөч рүүдийг түүж, галд хаяхад шатна.”

- *Иохан 15:6*

“Хэрэв Би зүрхэндээ хорон мууг хүндэтгэсэн бол Эзэн сонсохгүй. Эзэн Та. Θөрийн нэрийн төлөө, Миний их гэм нүглийг учлаач!”

- *Дуулал 66:18, 25:11*

“Харин аливаа зүйлд залбирлаараа болон гүйлтияараа, талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл.”

- *Филиппий 4:66*

## ЗАЛБИРАЛ БОЛ БУРХАНТАЙ НӨХӨРЛӨХ НӨХӨРЛӨЛ БИЛЭЭ

“Учир нь Эзэн Өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно. Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.”

- 1 Тесалоник 4:16, 17

Хайрт хүмүүс минь, эдгээр амлалтууд байгаа тул бид өөрсдийгүй махан биений ба сүнсний бүх л бузар булагтаас цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун байдлыг төгс болгоё.

- 2 Коринт 7:1

“Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг үзэгдэх үед бид Түүний өмнө зоригтой байж, Түүнийг ирэхэд өмнө нь ичгүүргүй байх болно.”

- 1 Иохан 2:28

“Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал. Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн тулд бие биенийхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч хаалган дээр зогсож байна.”

- Иаков 5:8, 9

“Та нар ч мөн бэлэн байгтун. Та нарын бодоогүй цагт чинь Хүний Хүү хүрч ирнэ.”

- Лук 12:40

## БУРХАНЫ СҮНСЭЭР ДҮҮРЭН БАЙ

“Миний зэмлэлд эргэн ханд! Харагтун, би та нарын дээр сүнсээ бялхуулна, та нарт үгээ мэдуулнэ.”

- *Сургаалт угс 1:23*

“Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно.”

- *Үйлс 2:386*

“Дарсанц бүү согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн байж, дуулал магтуу ба сүнслэг дуунуудаар нэг нэгэнтэйгээ ярилцаж, Эзэнд хандаж, зүрхэндээ дуулж, ая дуу зохиогтуун. Христээс эмээн нэг нэгэндээ захирагд.”

- *Эфэс 5:18-19,21*

“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.”

- *Филиппой 2:13*

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? Учир нь та нарыг үнээр худалдан авсан юм. Тиймээс биеэрээ Бурханыг алдаршуулагтуун.”

- *1 Коринт 3:16, 6:20*

“Бүгд Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үтийг зоригтойгоор ярьж эхлэв.”

- *Үйлс 4:316*

*Та Есүс Христийн тухай илүү  
ихийг тэдэхийг хүсвэл доорхи  
хаягуудаар зочилно уу.*

*www.lamcc.us*

*www.ltime.fr*